



ЦӨМИЙН АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ ТУХАЙ КОНВЕНЦИД НЭГДЭН ОРОХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Нэг Нэгдэн орох үндэслэл, шаардлага

1.1. Хууль зүйн үндэслэл, шаардлага

Монгол Улс нь 1985 онд Цөмийн материалыг биечлэн хамгаалах тухай конвенц, 1987 онд Цөмийн ослын талаар шуурхай мэдээлэх тухай конвенц, Цөмийн болон цацрагийн аюултай байдал бий болсон тохиолдолд тусламж үзүүлэх тухай конвенцид тус тус нэгдэн орж, соёрхон баталсан.

2009 онд Монгол Улсын Их Хурлаас Цөмийн энергийн тухай хууль болон “Монгол Улсын төрөөс цацраг идэвхт ашигт малтмал болон цөмийн энергийн талаар баримтлах бодлого”-ыг тус тус баталсан бөгөөд Цөмийн энергийн тухай хуулиар Монгол Улсын нутаг дэвсгэрт цацраг идэвхт ашигт малтмал болон цөмийн энергийг энхийн зорилгоор ашиглах, цөмийн болон цацрагийн аюулгүй байдлыг хангах, хүн ам, нийгэм, байгаль орчныг ионжуулагч цацрагийн сөрөг нөлөөллөөс хамгаалахтай холбогдсон харилцааг зохицуулахаар заасан.

Улсын Их хурлын 2010 оны 48 дугаар тогтоолоор баталсан Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд цөмийн эрчим хүчний салбарыг үндэсний ашиг сонирхол, энхийн зорилгоор ашиглах зарчимд нийцүүлэн хөгжүүлнэ. Түүнчлэн цөмийн циклийг хөгжүүлж, цацраг идэвхт ашигт малтмалын ашиглалт, боловсруулалт, хөрвүүлэлт, баяжуулалт, эрчим хүчний үйлдвэрлэлийг бий болгож хөгжүүлэхээр, Улсын Их хурлын 2011 оны 10 дугаар тогтоолоор баталсан Монгол Улсын гадаад бодлогын үзэл баримтлалд Монгол Улс олон улсын эрх зүйг хүндэтгэн сахиж, гэрээ, хэлэлцээрээр хүлээсэн үүргээ биелүүлнэ, Монгол улс дэлхийн хамтын нийгэмлэгийн гишүүний хувьд бүс нутгийн болон дэлхийн чанартай тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн бүх нийтийн үйл хэрэгт хувь нэмэр оруулах хүчин чармайлт гаргахаар тус тус заасан.

Түүнчлэн “Монгол Улсын цөмийн зэвсгээс ангид байх статусыг шинэ түвшинд гаргах тухай” Улсын Их хурлын 2015 оны 6 дугаар сарын 19-ний өдрийн 60 дугаар тогтоолд Цөмийн аюулгүй ажиллагааны тухай 1994 оны конвенц, Ашигласан түлшний болон цацраг идэвхт хаягдлын менежментийн аюулгүй ажиллагааны тухай 1997 оны конвенц, Цөмийн материалыг биечлэн хамгаалах тухай 1980 оны конвенцын 2005 оны нэмэлт өөрчлөлт, Бага хэмжээний цөмийн

материалын шинэчилсэн протоколд тус тус нэгдэн орох талаар холбогдох арга хэмжээ авахыг Засгийн газарт даалгасан болно.

Иймд дээр дурдсан Улсын Их Хурлын тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор Засгийн газрын 2016 оны 2 дугаар сарын 15-ны өдрийн хуралдаанаар “Цөмийн аюулгүй ажиллагааны тухай” 1994 оны конвенцид нэгдэн орох тухай асуудлыг хэлэлцээд Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороотой зөвшилцөхөөр шийдвэрлэсэн бөгөөд Улсын Их Хурлын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны 2016 оны 03 дугаар сарын 10-ны өдрийн хуралдаанаар уг конвенцид нэгдэн орох асуудлыг хэлэлцэн дэмжиж, зөвшөөрсөн.

Цөмийн энергийн комиссын 2022 оны хуралдаанаар хэлэлцүүлэн, Улсын Их Хуралд өргөн барих чиглэл өгсөн. Мөн Засгийн газрын 2023 оны 08 дугаар сарын 23-ны өдрийн хуралдаанаар Цөмийн аюулгүй ажиллагааны тухай 1994 оны конвенцид нэгдэн орох асуудлыг хэлэлцүүлж, хуралдааны 33 дугаар тэмдэглэлд конвенц, протоколыг хэлэлцэн дэмжиж Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороотой зөвшилцөхөөр тогтсон.

Улсын Их Хурлын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны 2023 оны 11 дүгээр сарын 21-ний өдрийн хуралдаанаар Цөмийн аюулгүй ажиллагааны тухай конвенцыг дэмжсэн.

Дээрх асуудлыг Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн хуралдаанаар танилцуулсан бөгөөд УИХ-ын 2024 оны ээлжит сонгуулийн дараа хэлэлцэхээр шийдвэрлэсэн.

1.2. Практик үндэслэл, шаардлага

Монгол Улс цөмийн төхөөрөмжгүй хэдий ч цөмийн түлшний циклийг бүхэлд нь хэрэгжүүлдэг, цөмийн зэвсэгтэй хоёр их гүрний дунд оршиж байдаг газар зүйн онцлогтой. Монгол Улстай хиллэдэг ОХУ, БНХАУ-ын цөмийн төхөөрөмжийн аюулгүй байдал нь тухайн улсын хяналтын байгууллага, Олон улсын атомын энергийн агентлагийн нарийн чанд хяналтан дор байдаг хэдий ч болзошгүй ослын үед манай улсад цацраг идэвхт бохирдол үүсгэх эрсдэлтэй юм.

Цөмийн ослоос үүссэн цацраг идэвхт бохирдлын тархалт нь ослын зэрэглэлээс хамаарч хэдий хэмжээний радиуст тархах нь харилцан адилгүй байдаг. Тухайлбал: 1986 онд тохиолдсон Чернобылийн цөмийн цахилгаан станц ослын үед Улаанбаатар хот болон зарим аймгийн агаарын цацрагын тунадас, тоосонцор, аерозолын дээжинд хийсэн хэмжилтээр цацраг идэвхт бодис нь 9 хоногт манай оронд мэдрэгдэж байгалийн дэвсгэр түвшний хэмжээг тодорхой хугацаанд нэмэгдүүлсэн боловч хүн амын эрүүл мэндэд нөлөөлөх хэмжээнд хүрээгүй байна.

Хоёр. Хуулийн төслийн ерөнхий бүтэц, зохицуулалт, хамрах хүрээ, хүлээх эрх, үүрэг

Хуулийн төсөлд Цөмийн аюулгүй ажиллагааны тухай 1994 оны конвенцид нэгдэн орох тухай асуудлыг тусгана.

Цөмийн аюулгүй ажиллагааны тухай 1994 оны конвенцыг Олон улсын атомын энергийн агентлагийн гишүүн орнуудын санаачилгаар 1994 онд баталж, 1996 оны 10 дугаар сарын 24-нд хүчин төгөлдөр болсноос хойш бүх улс нэгдэн ороход нээлттэй байгаа бөгөөд 2024 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн байдлаар 95 орон нэгдэн орж, 65 улс гарын үсэг зурсан байна.

Конвенцын зорилго нь олон улсын хамтын ажиллагааг бэхжүүлэх замаар дэлхий дахинд цөмийн аюулгүй ажиллагааг ханган тогтвортой байдлыг сахих, цөмийн төхөөрөмжөөс үүсэх ионжуулагч цацрагийн сөрөг нөлөөллөөс иргэд, нийгэм болон хүрээлэн буй орчныг хамгаалах зорилгоор болзошгүй цацрагийн ослын эсрэг үр ашигтай хамгаалалтыг бий болох, хэрэгжүүлэх, цацрагийн ослоос урьдчилан сэргийлэх, осол гарсан тохиолдолд сөрөг үр дагаврыг багасгахад оршино. Энэхүү конвенц нь цөмийн төхөөрөмжийн аюулгүй ажиллагааг хангахад үйлчилнэ.

Гурав. Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсэх нийгэм, эдийн засаг, хууль зүйн үр дагавар, ач холбогдол

Хуулийн төсөл батлагдсанаар манай улсад цөмийн энергийг энхийн зорилгоор ашиглах үйл ажиллагааг цөмийн аюулгүй байдлын олон улсын хэм хэмжээ, шаардлагын дагуу нийцүүлэн хэрэгжүүлэх нөхцөл бүрдэнэ.

Түүнчлэн шинээр барих, үйл ажиллагаа явуулж буй цөмийн байгууламж нь түүний ойр орчимд байх Хэлэлцэн тохиролцогч талуудад нөлөөлж болзошгүй байдаг тул тухайн Хэлэлцэн тохиролцогч талтай зөвлөлдөх, хүсэлт гаргасан тохиолдолд цөмийн байгууламжийн талаарх дэлгэрэнгүй мэдээлэл авах замаар манай орны хүн ам, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг багасгах, аюулгүй байдлыг хангах боломж бүрдэнэ. Мөн өөрийн нутаг дэвсгэр дээрх гадны нөлөөллийг тооцох, аюулгүйн үнэлгээг хийх, хил орчимд ослын үед хэрэгжүүлэх төлөвлөгөө боловсруулах, хариу арга хэмжээ авах, цацраг идэвхт хаягдалтай харьцах аль ч шатанд цацрагийн аюул болон цацрагийн сөрөг нөлөөллөөс хүн ам, нийгэм болон хүрээлэн буй орчныг үр ашигтай хамгаалах хяналтын тогтолцоо бий болох, шаардлагатай тохиолдолд олон улсын хамтын ажиллагааны хүрээнд техникийн дэмжлэг туслалцаа авах боломжтой болно.

Дөрөв. Хуулийн төсөл нь Монгол Улсын хууль тогтоомжтой хэрхэн уялдах, шинээр боловсруулах буюу нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох хуулийн талаарх санал

Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалтай нийцсэн байх бөгөөд бусад хууль тогтоомжтой уялдсан байна.

Хуулийн төсөлтэй холбогдуулан бусад хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагагүй.